

# Манмин Мэдээ

№ 36 2013 оны 7-р сарын 7

## Хуй салхи мэт Ариун Сүнсний нөлөө, хүчирхэг сүнсний сургаалиар Пакистанд болсон Номлогчдын семинар болон Эдгэрлийн гайхамшигт нэгдсэн их цуглаанд оролцож шинэ хүчийг олсон нь



Номлогчдын семинар болон Эдгэрлийн гайхамшигт цуглаанаар дамжуулан Есүс Христийн хайрыг дамжуулж, дагалдах тэмдэгт гайхамшигуудаар нь амьд оршигч Бурханыг батлан харуулахад Пакистан хүмүүсийн нүүрэнд сүнслэг амийн гэрэл гэрэлтэж байлаа. 1: Гил Тэй шик пастор гар алчуураар залбирч байна 2-4: Гэрчлэл хийж буй хүмүүс 5: Гил Тэй шик пастор удирдагч нартай хамт 6: Карачигийн номлогчдын семинар 7: Бурханы хүч чадлыг мэдрэхийн тулд 8000 хүн цугласан Лахорт болсон эдгэрлийн цуглаан

Пакистаны нийт хүн амын 97-оос илүү хувь нь Мусалман шашинтай. Ямар ч сүнслэг үржил шимгүй тэр газарт хүмүүс рүү хандсан Бурханы чин сэтгэлийн хайрыг илэрхийлсэн ариун сургаалын цэцэг цэцэглэсэн билээ.

И Жэй руг тэргүүн пасторын залбирал авч Бурханы хүч шингэсэн гар алчуур (Үйлс 19:11-12)-г аван өнгөрсөн 11 жилийн турш Гил Тэй шик пастор (Дэйжён Манмин Сүмийн хариуцагч пастор) нь Пакистаны нийслэл хот Исламабад болон өөр олон газруудад үйлчлэн семинарууд болон эдгэрлийн цуглааныг удирдаж байсан бөгөөд энэ удаад ч мөн 2013 оны 4-р сарын 5-15 хооронд тэрээр үйлчлэл хийхээр Пакистан руу явсан билээ.

Энэ удаад Пакистаны хоёрдахь том хот болох Лахоре болон Шейхупура, Мултан, Карачид зэрэг газруудад таван удаагийн номлогчдийн семинар болон эдгэрлийн гайхамшигт цуглаануудыг удирдан мөн сүмийн ахлагч нартай хоёр удаа уулзлаа. Энэхүү үйлчлэлийн үеэр ойролцоогоор 200 пастор өөрсдийнхөө сүмийг Манмины салбар сүм болон хамтран ажиллах сүмээр бүртгүүлж, маш олон эдгэрлийн илчлэгдсэнд оролцогчдын итгэл улам бүр өссөн билээ.

Хуй салхи мэт Ариун Сүнсний хүч чадал ба гайхамшигт гэрчлэлүүд

Лахорегийн Нэгдсэн Их Цуглаанд ойролцоогоор 8000 гаруй хүн оролцсон бөгөөд Гил Тэй шик пастор “Ариун Сүнс”

гэсэн сэдвээр сургаалыг Үйлс 2:1-4 ишлэлээр номлосон. Мөн тэрээр Шейхупура, Мултан, Карачид ойролцоогоор 6000 хүн, 3000 хүн, 450 хүн оролцсон Эдгэрлийн Нэгдсэн Их Цуглаануудад “Эдгээгч Эзэн” гэсэн сэдвэтэй сургаалыг Египетээс гарсан нь 15:26 ишлэлээр номлож, үг хуваалцлаа.

Сургаал номлосныхоо дараа Гил Тэй шик пастор өвчтэй хүмүүсийн төлөө гар алчуураар залбирал хийхэд үй олон хүн өвчин зовлон, сул дорой байдлаасаа чөлөөлөгдөж, эдгэрсэн байна.

11 настай Шираз холын хараа муу сайн харж чаддаггүй байсан бол залбирлын дараа маш сайн харж чаддаг болсон. 8 настай Умалали гурван настайгаасаа эхлэн ярьж чаддаггүй хэлгүй байсан бол ярьдаг болсон. 45 настай Шакина аарцаг гуяны мэс засал хийлгэсэнээс хойш таягтай явдаг болсон. Харин залбирлын дараа шууд таяггүй ганцаараа явж чаддаг болов. 35 настай Нашин тахир дутуу хүний тэргэнцэрээсээ босоод ганцаараа явж чаддаг болсон байна.

50 настай Юусеф Маших баруун мөрний саажилттай байсан бол одоо ямарч зовиургүйгээр баруун гар, мөрөө чөлөөтэй хөдөлгөж чаддаг болжээ. 7 настай Сахрил төрөлхийн астма өвчтэй байсан нь эдгэрсэн. 25 настай Авид ходоодны өвчнөөр зовж шаналж байсан ахынхаа өмнөөс залбирал авахад ах нь эдгэрч, баяр хөөрөөр дүүрэн аз жаргалтай болсныг баглан гэрчилж байлаа.

Мөн 40 настай Бушира таван жилийн турш тархины хавдартай байсан нь

эдгэрсэн, 23 настай Шаниз Исаак телевизээр И Жей руг тэргүүн пасторын залбирлаар жирэмсэлж хүүхэдтэй болох ерөөлийг авчээ. (захирал Анвар Фазал пастор)

Пакистанд болон Ойрхи дорнодод Исаак телевизээр И Жей руг тэргүүн пасторын сургаалуудыг Англи, Урду хэлээр өдөрт 6 цагийн турш нэвтрүүлдэг болсон байна.

Үг сургаалаар дутагдаж байсан орон нутгийн пасторууд сүнслэг гүн утгатай сургаалуудыг сонсоод гайхаж байв

Лахоред болсон номлогчдын семинарт пастор Гил Тэй шик пастор нь “Бүтээгч Бурхан” болон “Өнө эртнээс далдагдсан нууц” гэсэн үг сургаалыг дамжуулав. Шейхупура, Мултан, Карачид болсон номлогчдын семинарт тэрээр “Хүн Төрөлхтөнийг дагалдуулан боловсруулдаг Бурхан нь”, “Бурхан Сайн мууг мэдүүлэгч модыг бий болгосны учир” гэсэн сургаалуудыг номлолоо.

Үүнээс гадна Мөн тэр Пакистаны нэгдсэн удирдагчдын албан ёсны уулзалтанд оролцож Манмины ажил үйлчлэлийг танилцуулан Ром 5:8 ишлэлээс “Яагаад зөвхөн Есүс Христ бидний Аврагч Эзэн Болох” гэсэн үг сургаалыг номлов. Мөн Лахорийн удирдагч нартай уулзаж Пакистанд хийх Манмины алсын хараа, зорилго чиглэлийг тайлбарлаж өгөв.

Семинарт оролцсон пасторууд “Ийм сүнслэг гүн гүнзгий утгатай сургаалуудыг урьд өмнө нь ердөө ч сонсож байсангүй” гэж ихэд гайхшран өгүүлж байв. Тэд

Манмины дэлхий дахинаа чиглэсэн үйлчлэлийг их сонирхож үүнтэй нэгдэх итгэл найдвараар дүүрэн байлаа.

Пастор Самуел гүн талархалтайгаар “Би оюутануудад Библиэс хичээл заадаг багш хүн. Харин өнөөдөр энд ирээд цаашдаа оюутануудад хичээл заахад маш их хэрэгтэй надад тус дэм болох цоо шинэ мэдлэгийг мэдэж авлаа” гэж ярьж байв. Пастор Асиф Аслам “Би юу ч мэддэггүй юм байна гэдгээ сая л мэдлээ. Ариун үг сургаалаар Бурхан биднийг сэргээж дахин шинэчилж өглөө. Ийм сайхан сургаал сонсох ивээл ерөөлийг өгсөн Бурхандаа үнэхээр талархаж байна” гэж онцлон дурдав.

Энэхүү үйлчлэлийн аялалаар тэд ариун үг сургаалыг ойлгож, Манмины үйлчлэлийг Пакистанд маш олон хүн мэддэг болж, Исаак телевизээр Тэргүүн пасторын сургаалуудыг сонсож, эдгэрэл ивээлийг авдаг боллоо.

Маш олон пасторууд И Жей руг тэргүүн пасторын 2000 онд Пакистанд хийсэн Нэгдсэн их цуглааныг Пакистаны түүхэнд болж байгаагүй тийм агуу цуглаан болсон гэж одоог хүртэл дурсан ярьж байлаа. Тэд нэгдсэн их цуглаан нь асар их нөлөө үзүүлж, өөрчлөлт авчирдаг гэж онцлон тайлбарлаж байв.

Мөн нэмж хэлэхэд энэхүү үйлчлэлийн аялал нь Пакистаны удирдлагуудтай холбоо тогтоож, үйлчлэлийнхээ цар хүрээг тэлэх алтан боломж олгосон үе байлаа. Энэ бүгдийг хийсэн Бурхандаа бүхий л алдар магтаал талархалыг өргөө!

# Хайр бол ихэрхдэггүй

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй.” (1 Кор 13:4)



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Итгэл, найдвар хоёр нь Тэнгэрийн оронд очихын тулд түр зуур хэрэглэдэг зүйл бол харин хайр нь үүрд мөнхийн зүйл юм. Тиймээс итгэл, найдвар, хайр гурав байдаг ч хайр бол хамгийн агуу нь юм. 1 Коринт 13-р бүлэгт сүнслэг хайрын 15 шинж чанарын 5 дахь нь “ихэрхдэггүй” гэсэн байдаг. Библид үзвэл ялангуяа Бурханы маш их дургүй атгаг байдлуудын нэг нь бардам зан юм.

### 1. Бардам хүний шинж чанар

“Ихэмсэг, бардам” зан нь хичнээн чухал байсан ч бусдыг хүндэтгэдэггүй харин тэднийг үл тоож бүх зүйл дээр тэднээс би илүү сайн, дээр гэж үздэг байна. Бардам хүмүүс бусдаас өөрсдийгөө ямагт дээгүүр тавьдаг. Тэд бусдыг дорд үзэж, үргэлж зааж сургаж байдаг бөгөөд ихэвчлэн өөрсдөөсөө дор санагдсан, чухал биш хүмүүстэй их дээрэлхүү, бардам, ихэмсэг байдлаар ханддаг. Бүр зарим тохиолдол өөрсдөөсөө дээгүүр хүнийг хүртэл үл тоон харьцдаг байна.

Иймэрхүү хүмүүстэй харьцахад тэд ер нь л доог дохуу хийж, дапаалаад эсвэл хэрүүл маргаан хийхэд хүргэдэг. Хамгийн муухай нь тэд уурлахдаа дэлбэртлээ, бүр галзууртлаа уурлаж өөрсдийнхөө зөв гэж зүтгэдэг. Тэгээд л энэ нь зодолдоход ч хүргэх тохиолдол бий. Сургаалт үгс 13:10-г уншвал “Их зан маргаан мэтгэлцээнд л хүргэдэг. Харин зөвлөгөөг авагсдад мэргэн ухаан байна” гэсэн байдаг. Мөн 2 Тимот 2:23-т “Харин мунхаг, эелдэг бус маргаанууд нь тэмцэл мөргөлдөөн бий болгодгийг мэдэх тул тэдгээрээс тагталз” гэсэн байдаг билээ.

Хүн бүр өөр өөрсдийн үзэж харсан, сонссон, сурсанаасаа шалтгаалаад өөр өөр мэдлэг, зан араншинтай байдаг. Бардам хүмүүс юу сурсан байдаг вэ

гэвэл яг үнэндээ тэд болж бүтэхгүй, буруу зүйлээр л дүүрэн байдаг. Цаг хугацаа өнгөрөх тусам л буруу сурсан, хуурамч мэдлэг улам л хагуурч өөрийнхөөрөө зүтгэж, өөрийгөө л зөвтгөдөг болдог байна.

Өөрийгөө зөвтгөх гэдэг нь өөрийнхөө зөв гэж зүтгэж, өөрийн бодол санаа болон гаргасан шийдвэртээ цаг хугацаа өнгөрсөн ч хатуу зогсохыг хэлнэ. Ингэж өөрийнхөөрөө зүтгэх тусам таны зан чанар ч хатуу болж, мэдлэгээрээ ч хүнтэй харьцахад улам л хэцүү бэрхшээлтэй болох болдог. Энэ нь “Би” гэсэн бардамнал таны дотор аль хэдийн хэлбэрээ олон байршсан тул ийм занг хаяхад амар биш байдаг.

Жишээ нь нэг доогуур байр суурьтай, ядуу хүний бодлыг авч үзэцгээе. Тэр зангиагаа тохируулан зүүсэн баян хүнийг хараад хувцасаараа гайхуулж байна гэж боддог эсвэл түүний эргэн тойронд хэн нэгэн хүн жаахан хүнд үг хэллэг хэрэглэвэл түүнийг үл тоож хүн гэж үзсэнгүй гэж боддог.

Мөн ихэмсэг хүн өөрийн буруугаа хүлээн зөвшөөрдөггүй, өөрийн бодсон бодол санаандаа хүрэх гэж өөрийнхөөрөө зүтгэдэг. Харин даруу төлөв хүн бол үүний эсрэг хичнээн өөрийнх нь зөв, бусдын буруу байсан ч хэрүүл тэмцэл хийдэггүй байна. Бусдыг дийлэх, дээрэлхэх гэсэн өчүүхэн ч хүсэл санаагүй учраас 100% үнэн байсан ч өөрийн буруу байж магадгүй гэж боддог байна.

Даруу зүрх сэтгэлд тэр хэмжээний бусдыг өөрөөсөө илүү дээр гэж хүндлэх сүнслэг хайр байдаг юм. Хэдийгээр өөрөөс нь ядуу, боловсрол муутай, сул дорой байсан ч даруу сэтгэлтэй хүн нь чин сэтгэлээсээ бусдыг өөрөөсөө илүү дээр үзэж, бүр жаахан хүүхэд байсан ч санаа тавьж чаддаг байна. Учир нь Есүсийн цусаар аврагдсан хүмүүс бүгдээрээ Бурханы хувьд үнэ цэнэтэй эрхэм нандин хүүхдүүд нь болдог гэдгийг мэддэг учраас тэр юм.

### 2. Махан биеийн бардамнал болон сүнслэг бардамнал

Бид бардам зан гаргах, бусдыг үгүйсгэх гэх мэт ихэмсэг сайрхсан зан чанар гаргаж байгаа үйлдлийг амархан олоод харчихдаг. Эдгээрийг л “махан биеийн бардамнал” гээд байгаа юм шүү дээ. Ихэнх Христчин хүмүүс Есүс Христийг хүлээн авч, үнэнийг мэдсэн цагаасаа эхлээд эдгээр муухай зан чанараасаа салахыг хичээн зүтгэдэг. Махан биеийн бардамналыг хаяж, сүнслэг бардамналыг олж авах нь тийм

ч амар хялбар зүйл бас биш юм.

Тэгвэл “Сүнслэг бардамнал” гэж чухам яг юу юм бол? Хэрэв та Христэд итгээд удаж байгаа бол таны Библийн мэдлэг их байж ч болох юм. Та удирдагч эсвэл ямар нэгэн үүрэгт ажил хариуцан авсан, цол хэргэмтэй ч байж болно. Энэ хугацаанд та бүхний зарим нь Бурханы үг сургаалыг зүрх сэтгэлдээ буруу суулгаж, зүгээр л мэдлэг болгон үлдээгээд андуу ташаа ойлгосон байж болох юм. Мөн та буруу зөвийг жинхэнэ үнэнч шударгаар ялгаж салгаж чаддаг гэж боддог ч байж болох юм. Яг үнэндээ бол та бусдын алдаа дутагдлыг олж хардаг, шүүн дүгнэн тэднийг буруутгалд оруулдаг байна.

Зарим хүмүүс өөрсдийн эрх ашгийн төлөө бол ямар ч зүйл байсан тогтсон ёс, дэг журмыг зөрчин байж хийдэг байна. Тэгээд тэд дүрэм журмыг илэрхий зөрчсөн мөртлөө “Энэ зэргийн зүйл надад зүгээр. Би бол ийм өндөр албан тушаалын хүн” гэж боддог. Энэ мэт өөрийгөө өргөмжилдөг сэтгэлийг “Сүнслэг бардамнал” гэдэг. Ингэж өөрийгөө өргөмжилж Бурханы тушаалыг үл тоомсорлодог мөртлөө “Бурханд хайртай” гэж хэлдэг ч энэ нь үнэн үг байж чаддаггүй. Мөн та бусдыг буруутгадаг, шүүн дүгнэдэг бол жинхэнэ хайрын тухай ярих ч хэрэггүй юм.

Хэн ч гэсэн ариун байдлыг олохын өмнө бардамнаж болох шинж чанар байдаг тул үүнийг уг үндсээр нь хаях нь бидний хувьд маш чухал юм. Хэрэв та гал халуун залбирлаар үүнийг бүрмөсөн авч хаяхгүй л юм бол та өөрөө ч мэдэлгүй их зантай биеэ тоосон нэгэн болж болзошгүй учраас тэр юм. Энэ нь яг л үндсээр нь зулгааж хаяагүй зүгээр л тасдаад хаячихсан хогийг зэрлэг ургамал дахин ургаж байгаатай адил юм. Өөрөөр хэлбэл бид бүхэн гэм нүгэл, хорон муу зан чанараа бүрмөсөн хаяхгүй бол хичнээн Христчин амьдралаар амьдарсан ч бардамнал бидний зүрх сэтгэлд дахин ирдэг байна.

Тиймээс бид Бурханы өмнө үргэлж бяцхан хүүхдүүд мэт өөрсдийгөө даруу төлөв болгож, нэг нэгнийгээ өөрсдөөсөө илүү дээр чухалд тооцож, хамгийн дээд зэргийг хайрыг олж авах хүртлээ үйлчилж, хувирашгүйгээр зүтгэх хэрэгтэй.

### 3. Бардам хүн өөртөө л итгэж найддаг

Вавилоны Хаант Улсын хаан Небухаднезар хаант улсынхаа алтан

үеийг бий болгож, дэлхийн долоон гайхамшигийн нэг Вавилоны Цэцэрлэгийг босгон байгуулсан билээ. Тэр өөрийн агуу их хүч чадлаараа мөн өөрийнхөө нэр алдар, сүр жавхлангийн төлөө ийм гайхамшигт хотыг босгон бүтээн байгуулж, хүмүүст бурхан мэт хүндлэгдэнэ гэж бодсон. Эцэст нь харин Бурхан хүн төрлөхтөний захирагч гэдгээ энэ бардам хаанд мэдрүүлсэн юм (Даниел 4:30-32).

Эцэстээ хаан ширээнээсээ бууж, амьдарч байсан газраасаа хөөгдөж, үхэр шиг өвс идэж, үс нь бүргэдийн өд мэт ургатлаа долоон жилийг өнгөрүүлдэг. Үүний дараа түүний зүрх сэтгэл нь өөрчлөгдөж, шинэчлэгдэн ариусаж чадсан юм. Тэр өөрийн бардамнал болоод төгс хүчит Бурханыг жинхэнэ үнэнийг таньж мэдсэн билээ (Даниел 4:33-37).

Бурханд үл итгэгч олон хүн Небухаднезар хаан шиг өөртөө итгэж байдаг. Гэвч тэдний амьдралд хүн хэцүү асуудал, зовлон бэрхшээл ирэхэд хүний хүч чадлаар шийдвэрлэж чадахгүйд хүрдэг. Хэдийгээр шинжлэх ухаан, эм тариа гайхамшигтайгаар хөгжиж байгаа ч эдгэшгүй шинэ төрлийн өвчин, газар хөдлөлт, хар салхи мэтийн байгалийн давтагдашгүй хүчин зүйл, гай гамшгийг өмнө яаж чадахгүй хүчин мөхөсддөг билээ.

Хамгийн харамсалтай нь зарим итгэгчид хүртэл өөртөө итгэж, энэ дэлхий ертөнцийн аргаар асуудлыг шийдвэрлэх гэдэг юм. Бурхан тэдэнд туслахыг үнэхээр их хүсдэгч бардам зангаас нь болоод юу ч хийж чаддаггүй байна. Тиймээс тэд Сатан, диаволын заль мэх, дайралт довтолгооноос Бурханаар хамгаалагдаж чаддаггүй, зөвийн замаар замчлагдаж ч чаддаггүй байна.

Хайрт итгэгч нараа,

Бурхан бардам хүнийг мунхаг хэмээн айлдсан билээ. Хүн бол агуу хүчит Бурханы өмнө ердөө зүгээр л нэг бүтээл нь юм. Хэдий танд бахархах олон зүйл байлаа ч, энэ дэлхийн амьдрал бол түрхэн зуурынх бөгөөд шүүлт байгаа нь гарцаагүй үнэн юм шүү.

Бид бүхэн Бурханы оршихуйд өөрсдийгөө даруу болгож, Түүнд үйлчсэн хэмжээгээр Тэнгэрийн оронд өргөмжлөгдөх болно. Тиймээс Иаков 4:10-д “Эзний оршихуйд өөрсдийгөө даруу болго. Тэгвэл Тэр та нарыг өргөмжлөх болно” гэж айлдсанчлан Эзэн таныг өргөмжлөх болно. Иймээс өөрсдийгөө даруу болго. Та бүхнийг Бурханы өмнө гайхалтай үнэ цэнэтэй нэгэн болохийн төлөө би Их Эзний нэрээр хүсэн ерөөе.

## Монгол Манмин Төв Сүм

### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

### Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С  
**Утас:** чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org  
www.manmintv.org

# Жинхэнэ ивээлийг бидэнд ухааруулж өгдөг “Найман ерөөл”

Есүс уулан дээр үй олон хүнд гайхамшигт эрдэнэ мэт сургаалаа зааж номлосон. Үүнийг “Уулан дээрх сургаал” гэдэг. Тэдний нэг нь болох “Найман ерөөл” сургаал нь түр зуурын манан адил амьдралтай хүмүүст мөнх амьдрал, тэнгэрийн орны хаанчлалд орох жинхэнэ ивээлийн тухай заасан байдаг билээ. Бурханы сэнтий оршин буй Шинэ Иерусалимд орохыг хүсэж буй итгэгч нарт өөрийн итгэлээ эргэн харах эрхэм боломж олгодог билээ. Тиймд “Найман ерөөл”-н тухай үзэцгээе!



Есүсийн ууланд сургаалиа айлдаж байсныг дурсгал болгон босгосон “Найман ерөөл” цуглаан

**“Сүнсэн дотроо ядуу хүмүүс ерөөлтэй еэ. Учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм.” (Матай 5:3)**

“Сүнсэн дотроо ядуу” байх гэдэг нь бардам зангүй, ихэрхдэггүй, хувиа хичээдэггүй, хорон муугүй, хувийн эрх ашгийг харахгүй байхыг хэлнэ. Тиймээс “сүнсэн дотроо ядуу” хүмүүс үг сургаалыг маш амархан хүлээн авдаг. Ингэж Есүс Христийг хүлээн авсанаар тэд сүнслэг зүйлсийг хүсэн тэмүүлдэг бөгөөд Бурханы хүч чадлаар маш хурдан өөрчлөгдөж чаддаг байна.

Сүнсэн дотроо ядуу болохын тулд бид бүхэн махан биений шунал, нүдний хүсэл тачаал, амьдарлын бардам бахдалыг хаях хэрэгтэй. Үргэлж даруу сэтгэлээр сургаалиар дамжуулан өөрийн дотор байгаа хорон муу, муу муухай бүхнийг олж мэдээд гал халуун залбирлаар тэр бүгдийг хаяж, сүнслэг хүүхэд болох хэрэгтэй байдаг. Тийм болох үед л жинхэнэ мөнхийн ерөөл, өөрөөр хэлбэл Тэнгэрийн орныг эзэмшиж чадна.

**“Гашуудаж буй хүмүүс ерөөлтэй еэ. Учир нь тэд тайвшрал авах болно.” (Матай 5:4)**

Энд “гашуудах” гэдэг нь өөрийн уйтгар, гунигаас болж зүрх сэтгэлээ өвтгөх махан биений уй гашуу, гашуудал биш харин Бурханы зөвт байдлын төлөө, хаанчлалын төлөө гашуудах сүнслэг гашуудлыг хэлж байна. Сүнслэгээр гашуудана гэдэг нь юуны өмнө сүнслэг хайр байх шаардлагатай юм. Энэ нь зүрх сэтгэлд дэх гэмээ гэмшин гашуудах нь хийсэн үйлдлийнхээ төлөө гэмших юм уу өөрийн үүрэг албаа гүйцэтгэж чадаагүй үед өөрийн үйлсээ эргэн санан гашуудах, мөн итгэлийн ахан дүүсийнхээ төлөө, өөр олон сүнснүүдийг аврахын төлөө ч гашуудах гашуудал байдаг. Ийм төрлийн гашуудалд Бурхан бидэнд юу хэрэгтэй байгааг өгөөд зогсохгүй Тэнгэрийн оронд шагнал болон хураагддаг.

**“Дөлгөөн хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд дэлхийг өвлөн авах болно.” (Матай 5:5)**

Сүнслэг дөлгөөн хүмүүс үнэн дотор маш хүчтэй, зоригтой байдаг хирнээ уян зөөлөн яг л хөвөн шиг зөөлөн зан ааштай байдаг. Тэд бусдыг уучилж, өршөөж, сайнаар хандаж, ойлгож чаддаг. Олон хүн тэднээс амар тайвныг мэдэрч, тэдэнтэй байх дуртай байдаг. Тиймээс тэд маш олон хүнийг авралын зам руу хөвлөн дагуулж, Тэнгэрийн оронд өргөн уудам газрыг шагнал болгон авч чаддаг юм.

**“Зөвт байдлын төлөө өлсөж цангагч хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд хангалуун байх болно.” (Матай 5:6)**

Зөвт байдал гэдэг нь Бурханы хүслийг дагах, өөрөөр хэлбэл сайн болон үнэний уг үндэс болох Бурханы үг сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхийг хэлдэг. Бид бүхэн Бурханы зөвт байдлыг амьдралдаа хэрэгжүүлэхийн төлөө өлсөж цангаад хоол хүнс, уух юмыг чин үнэнээсээ хайж байгаа хүн шиг хайх хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл сүнслэг өлсгөлөн, цангаагаа тайлахын тулд бид Хүний Хүүгийн цусыг ууж, махыг идэх хэрэгтэй болдог.

Бурханы үг сургаалыг хичээнгүйлэн сонсон дуулгавартай байж, амьдралдаа хэрэгжүүлэх хэрэгтэй гэсэн утгатай юм. Хэрэв бид Бурханы үгийг сонсоод зүрх сэтгэлдээ гүн суулгаж, хэрэгжүүлвэл энэ нь зөвт байдлын төлөө өлсөж цангаж байна гэсэн утгатай бөгөөд ингэж өлсөж, цангаснаар сүнс сэтгэл маань амжилтанд хүрвэл худал хуурмаг, ёс бус зүйл байхгүй болно.

**“Энэрэнгүй хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд өршөөл энэрлийг хүртэх болно.” (Матай 5:7)**

“Энэрэнгүй” гэдэг нь бусдыг ойлгох, уучлах, хичнээн тэд бидэнд ямар ч учир шалтгаангүйгээр муу хандаж, хорон мууг үйлдсэн ч зөвийн замаар удирдан замчилж, дагуулж явахыг хэлнэ. Өөрийн байр суурьнаас, өөрийн эрх ашгийг бодох биш харин бусдын байр суурьнаас, бусдын эрх ашгийн төлөө бодож чадвал бид тэднийг ойлгож, уучилж, энэрч чадах юм.

“Энэрч, өрөвдөж, өршөөх” маш олон арга замаар байна. Жишээ нь уучлах, шийтгэх, туслаж дэмжих гэх мэт. Хэрэв бид бусдыг уучилж, өршөөл үзүүлвэл, Бурхан биднийг мөн уучилж, бидэнд ивээл ерөөлийг ч өгөх болно.

**“Зүрхэн дотроо цэвэр ариун байгч хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд Бурханыг харах болно.” (Матай 5:8)**

“Зүрхэн дотроо цэвэр ариун байх” гэдэг нь сурсан мэдсэн зүйлээ гаднаа зөвхөн үйлдэх биш мөн зүрх сэтгэл дотроо ч бас цэвэр ариухан байхыг хэлнэ. Бид сэтгэл зүрхээ ариун болгохын хирээр хорон муу зан чанараа сэтгэл зүрхнээсээ авч хаяж, Бурханы үг тушаалын дагуу амьдарч, үнэн ба сайн сайханаар өөрсдийгөө дүүргэхийг хэлж байгаа юм. Ингэж Бурханы үг тушаалыг амьдралдаа

хэрэгжүүлэхэд бидэнд хичээл зүтгэл, сэтгэлийн тэнхээ хэрэгтэй байгаад зогсохгүй Бурханы ивээл, хүч чадал, Ариун Сүнсний тусламж ч бас маш их хэрэгтэй байдаг. Эндээс “Бурханыг харах” гэдэг нь Түүний дүр төрхийг яг бодитоор харна гэсэн үг биш харин гуйлт болон залбирлынхаа хариултыг авч, зүрхнийхээ хүслийг биелүүлж, өөрийн амьдралдаа жинхэнэ Бурхан байна гэдгийг мэдэрч болох бүхий л арга замыг хэлж байгаа юм.

**“Амар тайвныг тогтоогч хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэх болно.” (Матай 5:9)**

Амар тайван байх, эвтэй байх гэдгийн сүнслэг утга нь бусдын төлөө өөрийнхөө амьдралаа ч зориулан золиослох гэсэн утгатай. Бурхан болон бидний дунд босгосон гэмийн ханаа нураасан үед л бид Бурхантай эв нэгдлийг тогтоон амар тайван байдлыг олж, худал хуурмаг үзэн ядах зэрэг гэм нүгэл хорон муу зан чанараа хаяж бусадтай эв нэгдэлтэй, амар тайван байж чадна.

Бүх зүйлд өөрийгөө золиослон хорон муугийн бүхий л хэлбэрийг хаявал бид Түүнтэй эв нэгдлийг тогтоож, Бурханы хүүхэд гэж нэрлэгдэх болно. Мөн бид Есүсийн адил сүнслэг эрх мэдэл, хүч чадлыг ч авч чадна (Матай 10:1). Мөн түүнчлэн, Бурханы сэнтий оршин байх Шинэ Иерусалимд орж, агуу сүр жавхлантай Бурханы жинхэнэ хүүхдийн эрхийг эдлэх болно.

**“Зөвт байдлын төлөө хавчигдсан хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм.” (Матай 5:10)**

Бурханы үнэн үг, тушаалын дагуу амьдрахад заримдаа бидэнд маш их хавчлага, дарамт, шахалт 2Тимот 2:12-д бичсэнчлэн тулгардаг. Гэрэл байгаа газар харанхуй сарнин алга болдогийн адил олон итгэгчид гэрэл болсон Бурханы үгэн дотор өсөж хөгжихөд дайсан сатан, диаволын хүч чадал нь суларч, сарнидаг байна. Дайсан сатан, диавол өөртөө хамааралтай энэ дэлхийн хүмүүсийг захирч байдаг. Тиймээс олон итгэгчдийг Христчин амьдралаар амьдруулахгүй байхын тулд тэднийг ашиглан шахааж, хавчихыг турхиран өдөөж, өөрсдийн эд багаж, зэвсгээ болгон ашигладаг юм.

Гэтэл Эзэний нэрээр хавчигдахдаа бид баяр хөөртэй байж чадахын гол учир нь Бурхан бидэнд өгөх шагнал нь агуу учраас тэр юм. Хавчлага дарамт, сорилтыг даван туулсанаар бидний итгэл улам өсөж, илүү сайн тэнгэрийн оронд очих болно.

## Улаанбаатар Манмин Сүм

### Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

### залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

### Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:  
Г. Анхбаяр СМТ 976-91173712  
976-91615337

Е- шуудан: power3712@gmail.com

### Mongolian

## Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
http://www.manmin.org/english  
www.manminnews.com  
e-mail: manminministry@hotmail.com  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин

# “Сэтгэлийн шарх болоод өвчнийг минь эдгээж өгсөн Эзэндээ талархаж байна”

Цэрэндоржийн Амараа туслагч (Монгол Манмин Сүм)

Би 5 настайдаа хойд эцэгтэй болж, хамт амьдрах болсон. Аав маань өөрийнхөө хүүхдүүдийг хайрлаж, заримдаа архи ууж, агсан тавьж, ээжийг маань ч зоддог болсон. Гэр бүлийн маань уур амьсгал иймэрхүү байсан болохоор би бусдыг хайрлаж, бас хайрлуулах гэдгийг мэдэхгүй өссөн. Би амьдралынхаа энэ мэт асуудлыг хүнээс нууж, хүнд муугаа үзүүлэхгүй гэсэн хатуу бодолтой, биеэ даасан хүүхэд байлаа. Цаг хугацаа өнгөрөх тусам би өөртөө л итгэдэг, их бардам зантай, бусдад итгэдэггүй хүн болсон байлаа.

1992 онд би анх сүмд явж эхэлсэн боловч тэр үед жинхэнэ үнэнийг мэддэггүй байсан учраас сүмийн зарим нэгэн хүмүүсийн хандлагаас сэтгэл минь шархалж сүмд явахаяа больж, Эзэнээс өөрөө холдсон билээ. Би багадаа шар өвчнөөр өвчилж элэг, бөөр муутай байсан. Бөөр давсагны үрэвсэлтэй байсан болохоор бие засахад маш хэцүү шархирч өвдөөд, шээс маань цустай гардаг байсан. Бөөр өвдөх үед нуруугаар өвдөж, заримдаа явж чадахгүй хэвтэрт орох үе ч байсан. 1996 онд дахин шарлаж элэгний В вирустэй болсон. Би гэрлэж хүү, охин хоёртой болж сайхан амьдарч байсан ч заримдаа нөхөртэйгээ муудалцаж, санал зөрөлдөх үе олон байлаа.

1998 онд Монгол Хэл бичгийн Дээд Сургуулийг Монгол, Англи хэлний багш орчуулагчаар төгссөн. 2011 онд Америк хүмүүсийн тусламжтайгаар Эзэн рүү эргэн ирсэн. Тэгээд нэгэн гэр хороололд гадаадын миссионерүүдийн тусламжтайгаар монгол гэр барьж, бүтэн сайн өдөр гэр цуглаан хийж, бусад үед нь англи хэл заадаг болсон.

2012 оны 5 сард Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Мөнхийн гэрэл цуглаантай хамтран ажиллаж, англи хэл зааж эхэлсэн билээ. Тус цуглааны Ариунцаг ахлагч надад монгол хэлээр хэвлэгдсэн Манмин сонинг өгсөн. Тэр сонинг уншаад хаягаар нь Монгол манмин сүмд ирж П.Батзориг ахлагчтай уулзсан. Тэр үед Эзний өдрийн Их мөргөлийг интернетээр Манмин Төв Сүмтэй шууд холбогдон хийж байв.

И Жей руг Тэргүүн пастор итгэлийн хадан суурин дээр сууриллагдахын тулд гэм нүгэлээ хаях тухай тайлбарласан сургаал номлож байсан. Энэ нь маш энгийн жишээгээр зааж



тайлбарлаж байсан болохоор их ойлгомжтой сэтгэл хүрсэн билээ. Бурханы хүслийг мэдэж, Ариун Сүнсээр дүүрч, сүнс минь дахин шинэчлэгдэж баяр хөөртэй байдаг болсон.

Удалгүй Монгол Манмин Сүмийн зуны цуглаан болж сайн мэдээ тунхаглагч Батзориг загалмайн утга учир гэсэн сургаал номлосон. Энэ сургаалиас Есүс яагаад аврагчаар ирсэн, цовдлогдсон гэх мэт маш олон зүйлийн утга учрыг сайн ойлгож мэдэж авсан билээ. Итгэлийн минь суурь дахин шинээр тавигдсан ивээлтэй цаг байлаа.

Галын наадам хийж Эзэнд магтан дууг өргөсөн тэр орой тэнгэрт үүлтэй байсан боловч итгэгчид Бурханд залбирч “Эзэн минь, Бурхан минь, бидэнд тэмдэгт гайхамшгаа үзүүлээч, Өөрийгөө амьд оршин байгаа гэдгээ илчлэн харуулаач” гэж чанга дуугаар хашхиран залбирахад тэнгэрт гайхалтай үзэгдэл болж маш олон од үнэхээр хөдлөж, бүжиглэх байгаа юм шиг хөдлөхийг би өөрийн нүдээр харсан билээ. Энэ нь надад Есүсийг төрөхөд гурван мэргэн хүн одны хөдөлгөөнийг харж, дагаж явсаар Есүсийн байгаа газар очдогийг санагдуулж байсан юм.

Үүний дараа миний өвчин ч бас эдгэрэх боломжтой юм байна гэсэн итгэл төрөөд агуу хүчирхэг Бурхан Аавдаа өөрийн ийм муухай зан араншин, хийж байсан гэм нүглийнхээ төлөө чин сэтгэлээсээ гэмшиж, залбиран гуйж, магтан дуулж, Тэргүүн Пасторын сургаалын дараа хийдэг өвчин эдгээх залбирлыг авсан билээ. Тэр үеэс хойш би нэг ч удаа дахин өвдөөгүй, ямар ч өвчин зовиргүй болж, олон жилийн турш зовж шаналж байсан өвчин зовлонгоо мартсан юм. Бүх алдрыг Эзэндээ өргөж байна. Халлелүяа!

Энэ байдлыг минь харсан эмч дүү маань болон бусад ахан дүүс нар маань Бурханыг таньж мэдэж, сүм ирдэг болж байгаа билээ. Үүнээс гадна Бурханаас авсан бас нэг том ивээл бол 2012 оны 12-р сараас эхлэн Тэргүүн Пасторын “Итгэлийн хэмжээ” ном болон Манмин сонинг англиас монгол хэл рүү орчуулж байгаа билээ. Орчуулгын ажлыг хийж байхдаа Бурхан Аавын хүслийг бүр гүнзгий сайн мэдэж авч байгаадаа үнэхээр их талархаж, Бурханд ашиглагдаж байгаадаа талархаж байдаг. Надад ийм их аз жаргал, баяр хөөрийг өгсөн Бурхан Аавдаа бүхий л алдар магтаал, талархалыг өргөж байна.

## “Бүлээн Итгэлийн амьдралаар амьдарч байснаа гэмшиж, анхны хайраа сэргээсэн нь”



Чун Мариа эгч дүүс  
(Залуучуудын 1-р баг)

Би ахлах сургуулийн 3-р ангид байх үед итгэлийн амьдралд минь маш гайхалтай өөрчлөлт гарсан юм. Эзний өдрийн Их мөргөлийн дараа Тэргүүн пастор оюутан залуучуудад зориулан бага хэмжээний Эдгэрэл Ивээлийн Цуглаан хийсэн тэр үед энэ гайхалтай зүйл болсон билээ.

Тэргүүн Пастор маань маш олон оюутан, сурагчид энэ дэлхийн хорон муу, бузар амьдралд орж эхэлсэнд үнэхээр их гашуудан, харамсаж байсан юм. Тэр бидэнд гэм нүгэл бүү хийгээрэй Там, Тэнгэрийн Орон байгаа шүү гэж дахин дахин онцлон анхааруулж, Бурханы хайрыг бидэнд дамжуулж, Тэнгэрийн орны итгэл найдварыг бидний зүрх сэтгэлд суулгаж өгсөн юм.

Түүгээр ч зогсоогүй бүр чин сэтгэлээсээ оюутан, сурагчдын сургалтын төлбөр төлж, бас бусад мөнгө санхүүгийн тал дээр туслаж, шаардлагатай чухал ном сурах бичиг, өөр хэрэгцээтэй бүхий л зүйлийг худалдан авахад тусалдаг байсан. Үүнийг харсан залуучууд бид түүний хайрыг чин сэтгэлээсээ мэдэрч, өөрчлөгдөж эхэлсэн билээ.

Би ч гэсэн солонгосын үндэсний хөгжим дуртай учир хөгжмийн дасгал хийх мэргэжлийн хуучир хөгжимтэй болохыг хүсч байсан тул дотроо ичиж байсан ч хүсэлтээ Тэргүүн Пастортаа тавьсан юм. Тэгэхэд Тэргүүн Пастор маань энэ хөгжмийг баяртайгаар авч өгсөн болохоор түүний энэ их хайр, ивээл, ач тусыг нь би заавал хариулна гэсэн чин сэтгэл өвөрлөн суралцаж байлаа. Тэгээд бэлтгэл дасгалаа маш шаргуу хийж, Солонгосын Үндэсний Хөгжмийн Сургуульд орохоор бэлтгэж

эхэлсэн. Тэгээд би Солонгосын үндэсний хөгжмийн чиглэлээр Ёонгин Их Сургуульд шалгалт өгч тэнцсэн юм.

2013 оны 2-р сард надад маш хүнд өвчний шинж тэмдэг илэрсэн. Би маш их ханиаж, бүр цустай ханиадаг болов. Миний шинжилгээний хариу сүрьеэ өвчтэй болсон гэж гарахад маш их айж, гайхаж, өнгөрсөн амьдралаа эргэн харж гэмшин залбирч эхэлсэн. Тэгээд миний итгэлийн амьдрал ямар ч идэвхигүй, халуун ч биш, хүйтэн ч биш бүлээн байсан бөгөөд Бурханыг чин сэтгэлээсээ хайрлахгүй, дэлхий ертөнцийн зүйлд анхаарч байснаа олж мэдсэн юм. Орой бүр Даниел залбиралд очиж дэлхийн зүйлийг Аав Бурханаас илүү их хайрлаж байсаныхаа төлөө, гэр бүлээ хайрладаггүй байсаныхаа төлөө, бусдад талархдаггүй байсаныхаа төлөө гэмшин залбирч эхэлсэн билээ.

Ингэснээр Бурхан Аавын хайрыг зүрх сэтгэлдээ гүн мэдэрч, сүнсэлэг зүйлийн төлөө хүсэн тэмүүлдэг болсон. Би маш их гэмшиж, нулимс урсган залбирдаг болов. Тэгтэл миний ханиалга зогсож, цусаар бөөлжихөө ч больж хоолыг сайн идэж чаддаг болсон. Тэргүүн Пасторын залбирлыг авсаны дараа сүрээгийн ямар ч савханцар нян шинжилгээнд илрээгүй бүрэн эдгэрсэн билээ. Халлелүяа!

Энэ явдлаар дамжуулан зүрх сэтгэл дэх бүх алдаа дутагдал, хорон муу зан чанараа би жинхэнээсээ бүрмөсөн хаяагүй юм байна гэж бодсон. Тэгээд миний төлөө загалмайд цовдлогдсон Эзний хайрыг гүн мэдэрсэн билээ. Миний төлөө чин сэтгэлээсээ хичээнгүйлэн залбирч өгсөн Тэргүүн пастортаа баярлалаа.